

**ОЮУНЫ ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ
ЦАХИМ ХЭЛБЭРТ ОРУУЛАХ, МЭДЭЭЛЛИЙН САНГ ҮҮСГЭХ,
АШИГЛАХ, ТҮҮНИЙ БАЙНГЫН ТАСРАЛТГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ, НУУЦЛАЛЫН НАЙДВАРТАЙ
БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Оюуны өмчийн газрын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, удирдах, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1.Байгууллагын нийт ажилтан албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэхдээ энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

Гурав. Мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлэх

3.1.Оюуны өмчийн цахим мэдээллийн нэгдсэн сан (цаашид “цахим мэдээллийн сан” гэх) нь Оюуны өмчийн газарт мэдүүлсэн болон бүртгүүлсэн Аж үйлдвэрийн өмчийн цахим мэдээллийн сан, Зохиогчийн эрхийн цахим мэдээллийн сан, Хяналтын цахим мэдээллийн сан, Тусгай зөвшөөрөл, хамтран ажиллах этгээдийн цахим мэдээллийн сангуудаас бүрдэнэ.

3.2. Оюуны өмчийн газар нь цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл бүртгэх, хөтлөх, шинэчлэх, мэдээллийн нэгдсэн сангаас оюуны өмчийн холбогдох хууль, журамд нийцүүлэн мэдээллийг түгээх, цахимаар хэвлэн нийтлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

3.3.Цахим мэдээллийн нэгдсэн санд Оюуны өмчийн тухай хуулийн, 6 дугаар зүйлийн 6.3 хэсэг, мөн хуулийн 7 дугаар зүйлд заасан мэдээллийг төвлөрүүлнэ.

3.4.Цахим мэдээллийн нэгдсэн сан нь дараах зүйлээс бүрдэнэ:

- 3.4.1.Аж үйлдвэрийн өмчийн удирдлагын IPAS систем;
- 3.4.2.Аж үйлдвэрийн өмчийн хайлтын IPOM Publish систем;
- 3.4.3.Цахим мэдүүлгийн Efiling систем;
- 3.4.4.Зохиогчийн бүртгэлийн систем;
- 3.4.5.Зохиогчийн эрхийн хайлтын систем;
- 3.4.6.Хяналтын цахим бүртгэлийн систем;
- 3.4.7.Тусгай зөвшөөрөл, хамтран ажиллах этгээдийн бүртгэлийн систем;
 - 3.4.7.1.Оюуны өмчийн зуучлалын бүртгэл;

3.4.7.2.Оюуны өмчийн лицензийн гэрээний бүртгэл;

3.4.7.3.Оюуны өмчийн үнэлгээчний бүртгэл;

3.4.7.4.Оюуны өмчийн хамтын удирдлагын байгууллагын бүртгэл;

3.5.Оюуны өмчийн газар нь оюуны өмчийн мэдээллийн цахим санг бүрдүүлэх, хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллах хариуцсан албан хаагчийг (цаашид эрх бүхий албан хаагч гэх) томилж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

3.6.Эрх бүхий албан хаагч нь албан ёсны эх сурвалжийг үндэслэн хуульд заасан мэдээллийг цахим хэлбэрт үнэн зөв оруулах, системд байршуулах, цахим мэдээллийн санг үүсгэх ажлыг хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Цахим мэдээллийн нэгдсэн санг ашиглах

4.1.Энэ журмын 3.4-д заасан цахим мэдээллийн нэгдсэн санг дараах байдлаар ашиглана.

4.1.1.Энэ журмын 3.4.1-д заасан системийн мэдээллийг оюуны өмчийн газрын дарга, Аж үйлдвэрийн өмчийн холбогдох нэгжийн дарга, шинжээч, мэргэжилтэн;

4.1.2.Энэ журмын 3.4.3-д заасан системийг оюуны өмчийн итгэлмжлэгдсэн төлөөлөгч, мэдүүлэг гаргагчид;

4.1.3.Энэ журмын 3.4.4-д заасан системийн мэдээллийг оюуны өмчийн газрын дарга, Зохиогчийн эрхийн холбогдох нэгжийн дарга, шинжээч, мэргэжилтэн ашиглана.

4.1.4.Энэ журмын 3.4.2., 3.4.5.-д заасан системийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.

4.2.Энэ журмын 3.4.1., 3.4.4.-д заасан системд нэвтрэх эрхийг удирдах албан тушаалтны зөвшөөрлөөр системийн админ үүсгэх бөгөөд удирдах албан тушаалтан, шинжээч, мэргэжилтэн тус бүр өөр эрхийн хязгаарлалттай байна.

4.3.Цахим мэдээллийн санд нэвтрэх эрх бүхий албан хаагч мэдээлэл оруулахдаа, өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглана.

4.4.Энэ журмын 3.4-д заасан цахим мэдээллийн сангийн мэдээллийн үнэн бодит байдлыг дараах байдлаар хангана:

4.4.1.Энэ журмын 3.4.1-д заасан системийн мэдээллийн санд оруулж буй мэдээллийн үнэн бодит байдлыг тухайн эрх бүхий албан хаагч хариуцаж, Аж үйлдвэрийн өмчийн холбогдох нэгжийн дарга хяналт тавина.

4.4.2.Энэ журмын 3.4.4-д заасан системийн мэдээллийн санд оруулж буй мэдээллийн үнэн бодит байдлыг тухайн эрх бүхий албан хаагч хариуцаж, Зохиогчийн эрхийн холбогдох нэгжийн дарга хяналт тавина.

4.4.3.Энэ журмын 3.4.3-д заасан системийн мэдээллийн санд оруулж буй мэдээллийн үнэн бодит байдлыг тухайн мэдүүлэг гаргагч, оюуны өмчийн итгэмжлэгдсэн

төлөөлөгч өөрөө хариуцаж, Аж үйлдвэрийн өмчийн холбогдох нэгжийн дарга, системийн админ хяналт тавина.

4.5.Мэдүүлэг гаргагч, эрх эзэмшигч, зохиогч өөрөө Оюуны өмчийн газарт хүсэлт гаргах бөгөөд хүсэлтийг Оюуны өмчийн газрын удирдах албан тушаалтны зөвшөөрлөөр цахим мэдээллийн санд өөрчлөлт оруулна.

4.6.Цахим мэдээллийн санд мэдээлэл байршуулах, шинэчилэх, өөрчлөх, устгах эрхийг албан ёсны эх сурвалжийг үндэслэн зөвхөн эрх бүхий албан хаагч эзэмшинэ.

4.7.Эрх бүхий албан хаагч нь цахим мэдээллийн сангийн нууцлалыг хангаж ажиллана.

Тав. Цахим мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах

5.1.Цахим мэдээллийн сан дахь хуулиар хориглосноос бусад мэдээлэл нийтэд нээлттэй байна.

5.2.Системд нэвтрэх эрхийг удирдах албан тушаалтны зөвшөөрлөөр системийн админ үүсгэх бөгөөд эрхийн хязгаарлалт мэргэжилтэн, шинжээч, удирдах албан тушаалтан тус бүр өөр өөр байна.

5.3.Оюуны өмчийн газар нь цахим мэдээллийн сангийн найдвартай байдлыг дараах байдлаар хангана:

5.3.1.Мэдээллийн систем, цахим мэдээллийн сангийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, цахим мэдээллийн сангийн нөөцөлж хадгалах нөхцөлийг бүрдүүлэх.

5.3.2.Цахим мэдээллийн сан, программ хангамж, компьютерыг хортой кодоос хамгаалах.

5.3.3.Байгууллагын мэдээллийн системд ашиглах техник хэрэгсэл, програм хангамжийн гарал үүслийг бүртгэх, шаардлагатай тохиолдолд техникийн үзлэг хийх.

5.3.4.Байгууллагын компьютерын систем, серверт нэмэлт өөрчлөлт, шинэчлэлт, техникийн үйлчилгээг хийхэд гадны байгууллага, мэргэжилтнийг зайлшгүй ажиллуулах тохиолдолд тухайн ажлыг гүйцэтгэх байгууллагыг сонгох үйл явцад оролцох бөгөөд тухайн гүйцэтгэх явц, гүйцэтгэлд нь хяналт тавих.

Зургаа. Бусад

6.1.Цахим мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг Оюуны өмчийн газар хариуцна.

6.2.Цахим мэдээллийн сангаас мэдээлэл алдагдах, устсан тохиолдолд буруутай алба хаагчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.3.Албан хаагч нь ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд системийн зохицуулагч нь мэдээллийн систем, цахим шуудан, интернетэд хандах эрхийг хааж, тэмдэглэл хөтөлнө.

6.4.Энэ журмаас гадна Оюуны өмчийн газрын “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг баримталж ажиллана.

6.5.Энэхүү журам 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.